

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН
2018 ОНЫ 07 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2018 оны 07 дугаар сарын 25

Чойбалсан хот

Арга хэмжээ /гарц/-ийн шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа/-ийн хүрэх түвшинь	Жинхэнэ гүйцэтгэл /тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин/	Үнэлгээ /нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо/
1	2	3
<p>1.1.1. Орон нутгийн төрийн захиргааны болон хяналтын байгууллагуудаас зохион байгуулсан уулзалт, зөвлөгөөн, сургалтанд оролцох Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Байгууллагын үндсэн чиг үүргийг талаар үнэн зөв ойлголттой болсон байна Хугацаа: Сардаа</p>	<p>Бүсийн газрын дарга Д.Давааням Дорнод аймгийн “Удирдах ажилтны шуурхай хуралдаан”-д 6 удаа сууж, орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг чиглэл, мэдээллийг албан хаагч нарт 6 удаагийн шуурхай хуралдаан хийж танилцууллаа. Шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг даалгавар, анхаарах асуудлыг хуралдааны тэмдэглэлийг нийт албан хаагчдад дотоод сүлжээгээр хүргүүлсэн. Мөн Хэнтий аймгийн ахлах мэргэжилтэн Д.Дэлэг, Сүхбаатар аймаг дахь хэлтсийн дарга Х.Ургаа нар тус тус аймгийн удирдах ажилтны шуурхай хуралд байгууллага төлөөлөн сууж мэдээллээр хангагдаж байсан.</p>	
<p>1.1.2. Нутгийн захиргааны болон хяналтын бусад байгууллагатай хамтран ажиллах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль тогтоомжийн талаар нэг мөр ойлголт өгөх Хугацаа: Сардаа</p>	<p>Дорнод аймгийн Тагнуулын газар, Хилийн 0132-р анги, Прокурорын байгууллагуудын албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу гадаадын иргэдийн талаарх мэдээ, мэдээллийг солилцон ажилласан.</p>	
<p>1.2.1. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь газрын ажиллах журам”-ын хэрэгжилтийг ханган, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн ажиллах, үр дүнг тайлагнах</p>	<p>Тайлангийн хугацаанд Бүсийн газрын даргын А/24 тоот “Хариуцлагатай жижүүрийн хуваарь батлах тухай”, А/25 тоот “Албан хаагчдын хилийн боомтод ажиллах хуваарь батлах тухай”, А/26 тоот “Баяр наадмын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийн хуваарь батлах тухай”, А/27 тоот “ Удирдах, төлөөлөх эрх шилжүүлэх тухай тушаалыг тус тус батлан хэрэгжүүлж ажилласан.</p>	

<p>Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Үйл ажиллагааны үр дүн гарсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Байгууллагын даргын баталсан удирдлага зохион байгуулалтын А/211, А/219, А/227, А/238, А/240 тоот, хүний нөөц боловсон хүчинтэй холбоотой Б/186, Б/191, Б/193, Б/194, Б/205 тоот тушаал, шийдвэрийг тус тус хүлээн авч хэрэгжүүлсэн.</p>	
<p>2.1.1. Монгол Улсад цагаачлан оршин сууж байгаа гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт болон иргэний харьяаллын асуудлаар гаргасан бусад хүсэлтийг хүлээн авч зөвлөгөө өгөх, хүлээн авсан баримт бичгийн бүрдлийг Харьяатын газарт хүргүүлэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Тус сард харьяалалтай холбоотой ямар нэг хүсэлт хийгдээгүй.</p>	
<p>3.1.1. Гадаадын иргэнд Монгол Улсын энгийн зэргийн виз олгох, хугацаа сунгах, визийн зөвшөөрөл хүссэн тухай Виз, зөвшөөрлийн газарт уламжлан шийдвэрлүүлэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Бүсийн газар түүний харьяа хилийн боомтуудад БНХАУ-ын 117 иргэнд зохих ангилал, зориулалтын дагуух визийг олгосон. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “НГ” ангиллын визийг 82 иргэнд олгосон байна. Үүнээс: <ul style="list-style-type: none"> - Нэг удаагийн “гарах-орох” зориулалттай виз -24 - Хоёр удаагийн “гарах-орох” зориулалттай виз -5 - Олон удаагийн “гарах-орох” зориулалттай виз -23 - Визийн шилжүүлэг- 30 ; - “S” ангилалын нэг удаагийн “гарах-орох” зориулалттай виз 8 иргэнд ; - “Н” ангилалын нэг удаагийн “гарах-орох” зориулалттай виз 2 иргэнд; - “В” ангиллын визийг Виз, зөвшөөрлийн газраас олгосон визийн зөвшөөрлийн дагуу олон удаагийн “орох” зориулалттай виз 2 иргэнд - “Т” ангилалын нэг удаагийн “гарах-орох” зориулалттай виз 1 иргэнд ; - “TS” ангиллын визийг 3 иргэнд олгосон байна. Үүнээс: - “J” ангилалын нэг удаагийн “орох” зориулалттай виз 19 иргэнд тус тус олгож ажиллаа. 	

<p>3.1.2. Монгол Улсад зорчих хувийн урилга олгох Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга хүссэн гадаадын 8 иргэний материалыг хүлээн авч, БНХАУ-ын 8 иргэнд Монгол Улсад 30 хоног байх хугацаатай байх урилгыг олгосон.</p>	
<p>3.1.3. Оршин суух зөвшөөрөл, хугацаа сунгах, хасах, оршин суух үнэмлэх авах, өөрчлөлт бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авах, хянах хүсэлтийг хүлээн авч Виз, зөвшөөрлийн газарт уламжлан шийдвэрлүүлэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Ганхийц” ХХК-наас ирүүлсэн БНХАУ-ын 3 иргэнд оршин суух зөвшөөрөл авах тухай албан хүсэлтийн материалыг хүлээн авч Виз, зөвшөөрлийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлсэн.</p>	
<p>3.1.4. Монгол Улсад түр ирэгч гадаадын иргэнийг бүртгэх, хасах, түүнчлэн хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхтэй гадаадын иргэнийг бүртгэх, хасах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 2 аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу “HG” ангиллын “орох” зориулалтын визээр орж ирсэн БНХАУ-ын 6 иргэнийг түр ирэгчээр бүртгэсэн. Мөн зөрчил гаргасан 11 иргэнийг түр ирэгчээр бүртгэж, хасалт хийсэн байна. Бичигт, Сүмбэр, Баянхошуу, Хавирга боомтуудаар ХОНДЗҮ-р зорчсон БНХАУ-ын 255 иргэнийг бүртгэн, 234 иргэнд хасалт хийсэн.</p>	
<p>3.1.5. Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суухаар анх удаа ирсэн гадаадын иргэний хурууны хээ бусад мэдээллийг журмын дагуу авч нэгдсэн санд оруулах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Монгол Улсад анх удаа хөдөлмөр эрхлэхээр ирсэн 1 аж ахуйн нэгжийн нийт 20 гадаадын иргэний хурууны хээг “Transient card system” програмаар бүртгэн авч, мэдээллийн баазад оруулсан.</p>	

<p>3.2.1. Монгол Улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суугаа гадаадын иргэн, аж ахуй нэгж, байгууллагад удирдамжийн дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дангаар буюу хяналтын бусад байгууллагатай хамтран зохион байгуулна Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Гадаадын иргэн, харьяатын газрын Зүүн бүс дэх газар нь тайлангийн хугацаанд бүсийн газрын даргын баталсан №17/02-201823-17/02-201827 тоот удирдамжийн дагуу төлөвлөгөөт 1, төлөвлөгөөт бус 5 нийт 6 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.</p>	
<p>3.2.2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан зөрчил гаргасан гадаадын иргэдийн зөрчлийг арилгаж, зөвлөгөө өгч ажиллана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Хяналт шалгалтанд нийт 21 аж ахуй нэгж, гадаадын 174 иргэн хамрагдсанаас бүсийн хэмжээнд 10 зөрчлийг илрүүлж БНХАУ-ын 10 иргэнд 730.000.00 /долоон зуун гучин мянга/-н төгрөгийн торгуулийг ногдуулж ажилласан.</p>	
<p>3.2.3. Хууль, тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлсэн БНХАУ-ын 5 иргэн, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан БНХАУ-ын 3 иргэнийг Монгол Улсаас албадан гаргасан.</p>	
<p>3.2.4. “Монгол Улсын виз олгох журам”-ын 5.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр визийг хүчингүй болгоно Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Хавирга боомтод ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан БНХАУ-ын 1 иргэнтэй ярилцлага хийж визийг хүчингүй болгон хилээр нэвтрүүлэлгүй буцаасан, Бичигт боомтод зөрчил гаргасан БНХАУ-ын 3 иргэний визийг хүчингүй болгон ажиллаа.</p>	
<p>3.2.5. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, тогтоомжид заагдсан үндэслэлээр гадаадын иргэнийг Хил дээрээс буцаах арга хэмжээг журмын дагуу хэрэгжүүлж ажиллана Тоо хэмжээ: Тухай бүр</p>	<p>“Бичигт” боомтод хяналтын улсын байцаагч Ц.Өлзиймөнх; ГИЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1.6 дах заалтыг үндэслэн /Монгол Улсад байх буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй/ БНХАУ-ын 4 иргэн, визийн бичилт буруу бичигдсэн БНХАУ-ын 3 иргэн, нийт 7-иргэн;</p>	

<p>Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>“Хавирга” боомтод хяналтын улсын байцаагч Д.Мөнхбаяр ГИЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтыг үндэслэн /16 насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй гадаадын иргэн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй/ БНХАУ-ын 21 иргэн, мэргэжилтэн А.Нэмэхбаяр; ГИЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1.6 дах заалтыг үндэслэн /Монгол Улсад байх буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй/ БНХАУ-ын 3 иргэн, нийт гадаадын 24 иргэн; Бүсийн хэмжээнд БНХАУ-ын нийт 31 иргэнийг улсын хилээр нэвтрүүлэлгүйгээр буцааж ажилласан.</p>	
<p>4.1.1 2018 оны Бүсийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт болон хүний нөөц, бусад шаардлагатай судалгаа мэдээллийг гарган Тамгын газар, БОНХ-т хүргүүлэх, Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Дээд шатны байгууллага, албан тушаалтан хүссэн мэдээллээ авсан байна. Хугацаа: Сардаа</p>	<p>Төвөөс ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу Тамгын газарт албан хаагчдыг урамшуулах тухай илтгэх хуудас, шалгалт зохион байгуулсан талаар илтгэх хуудас хүргүүлэн, Боомт орон нутгийн хэлтэст бүсийн газрын 6 дугаар сарын тайлан, төлөвлөгөөний биелэлт, 7 дугаар сарын төлөвлөгөөг Байгууллагын даргын Үр дүнгийн гэрээний долдугаар сарын биелэлт, 8 дугаар сарын төлөвлөгөөний саналын хамт тус тус гаргаж “и оффис” хаягаар хүргүүлсэн. 2018 оны ээлжийн амралтаа эдэлж байгаа хяналтын улсын байцаагч Б.Ганзориг, Б.Хосбаатар нарын хувийн тэмдгийг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу Бүсийн газрын дарга акт үйлдэн хадгалалтад авсан.</p>	
<p>5.1.1. Хойд бүс дэх газрын албан хаагч нартай бүсийн газрын үйл ажиллагаатай танилцан туршлага солилцох Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Мэргэшлийн үр чадвар нэмэгдсэн байх Хугацаа: Сардаа</p>	<p>Зүүн бүс дэх газрын үйл ажиллагаатай танилцан туршлага судлах зорилгоор Хойд бүс дэх газрын 8 албан хаагч 2018 оны 07 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд Дорнод аймагт бүсийн газарт ажиллан бүсийн үйл ажиллагаа, санхүү, виз зөвшөөрөл, хяналт шалгалтын өдөр тутмын үйл ажиллагааг бүсийн газрын дарга Д.Давааням танилцуулан туршлага солилцон ажилласан.</p>	
<p>5.2.1. Байгууллагын баримт бичгийн эргэлтийг зохион байгуулах, бүртгэлжүүлэх, сан үүсгэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан</p>	<p><u>Ирсэн бичиг:</u> Гадаадын иргэн харьяатын газраас 4, бусад байгууллагаас 8 нийт 12 албан бичиг ирж, үүнээс хариутай 7 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд өгч шийдвэрлэсэн. <u>Явсан бичиг:</u> Гадаадын иргэн, харьяатын газарт 8, албан хаагчдад 3, бусад байгууллагад 15 нийт 26 албан бичиг явуулж үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, албан бичгийн хариуг хүргэж ажилласан.</p>	

<p><i>байна</i> Хугацаа: Сардаа</p>	<p><u>Өргөдөл:</u> Жолооч Т.Баярсайхан эрүүл мэндийн шалтгаанаар 1 жилийн чөлөө хүссэн өргөдлийг хүлээн авч төвд шилжүүлэн шийдвэрлэх шатанд явж байна.</p>	
<p>6.1.1. Төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллах. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Зориулалтын дагуу зарцуулсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Тус 7 дугаар сард 41,552,500.00 төгрөгийн санхүүжилтийг авсан. Үүнээс: урьдчилгаа цалин 26,137,455,53, сэлбэгэнд 165,000.00 нийт 42.677.907.33 төгрөгийн зарлагын гүйлгээг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу хийж гүйцэтгэсэн.</p> <p>2018 оны 06 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 249,519,300.00 төгрөгийн санхүүжилт, 212,580,601.09 төгрөгийн гүйцэтгэлтэй, 36,938,698.91 төгрөгийн үлдэгдэлтэй гарсаныг газрын даргаар баталгаажуулан аймгийн төрийн сан болон ГИХГ-ын санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.</p>	
<p>6.1.2. Тэмдэгтийн хураамжийн болон хүү, торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Хяналтын улсын байцаагч болон боомтын визийн хуудасны 06 дугаар сарын тайлангаар улсын тэмдэгтийн хураамж орлогод 4,748,000.00 төгрөг, хүү, торгуулийн орлогод 2,500,000.00 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.</p>	
<p>6.2.1. Бүсийн төв болон бусад нэгж, техник хэрэгсэлд шаардлагатай бараа материал, эд зүйлээр нь хангаж ажиллах Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тооцоо судалгаа хийгдсэн байна Хугацаа: Сардаа. /тусгай арга хэмжээ/</p>	<p>Бичиг хэргийн хэрэгцээнд сиди, диск 20 ширхэг, тушаалын бланк 200 ширхэгийг захиалан хийлгэсэн. Бичгийн цаас 4 боодлыг олгосон. Бүсийн төвд ашиглагдаж байгаа 75-55 ДОО улсын дугаартай “НИССАН ПАТРОЛ” автомашины аюулгүй байдлыг бүрэн хангах үүднээс түлшний дээд, доод шүүрийг шинээр сольж тавиулсан.</p>	
<p>6.2.2. Баянхошуу боомтод барих агуулах болон амралтын байрны засварын ажлын тооцоо, судалгааг гаргах, зарим материалыг хүргэх. Тоо хэмжээ: 1 удаа</p>	<p>Сүмбэр боомтын албан хаагчдын амьдрах байранд урсгал засвар хийхэд шаардлагатай бараа материалын тооцоо, Баянхошуу боомтын автомашины гражын гадна талыг засварлан сэргээх ажлын тооцоо судалгааг тус тус гарган ажилласан.</p>	

<p>Чанар: Материалын тооцоо бодитой байна. Хугацаа: Сардаа. /Тусгай арга хэмжээ/</p>		
<p>7.1.1. “ISM” системийн сайжруулалт, хөгжүүлэлтийг тухай бүр гүйцэтгэж, албанд ашиглана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Найдвартай системтэй байна Хугацаа: Жилдээ /тусгай арга хэмжээ/</p>	<p>Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Д.Одхүү, Хяналтын улсын байцаагч Д.Мөнхбаяр, Г.Хосбаатар, Б.Энхтулга, Ц.Анхбаяр, мэргэжилтэн Б.Одмаа, А.Нэмэхбаяр Х.Тайванбаатар нарын “ISM” програмын шилжүүлэх эрхийг дарга Д.Даваанямд илтгэх хуудсаар танилцуулан бүртгэн авч, мэдээллийн технологийн хэлтэст танилцуулан тус програмын эрхийг шилжүүлсэн. Eset endpoint security антирусны программыг хилийн боомтуудын нийт 10 компьютеруудад 07 дугаар сарын шинэчлэлтийг хийж хортой кодоос урьдчилан сэргийлсэн.</p>	
<p>7.1.2. Албан үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютер, тоног төхөөрөмжийн урсгал засвар үйлчилгээ, эвдрэл гэмтлийг тухай бүр засварлах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Үйл ажиллагааны тасралтгүй байдал хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Immigration.gov.mn сайтын “Зүүн бүс дэх газар” цэсэнд 06 дугаар сарын тайлан, төлөвлөгөөний биелэлт, 07 дугаар сарын төлөвлөгөө, мэдээ мэдээллийг шинэчлэн оруулсан. Хилийн боомтуудын ХУБ болон мэргэжилтэн нарт сүлжээ, “ISM” програм болон компьютер техникийн 4 удаагийн зөвлөгөө өгч ажилласан.</p>	

ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗАР